

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/91/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Эл Би Альфа Экспэйншин аудит ХХК-ны

Аудитор: Г. Баясгалан

Утас: 95438030

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
5.1 Залруулсан алдаа	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
НА	Нотлох Ажил
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ХШУДАГ	Хяналт Шинжилгээ, Үнэлгээ, Дотоод Аудитын Газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

**БУЛГАН СУМЫН НЭГДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
О. ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА**

2023.02.20 № 2/65
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.9.1-д заасны дагуу Булган сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮ-5 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 80 жилийн ойтой холбоотойгоор орон нутгийн хөгжлийн сангаас сумын иргэдийн хурлын тогтоолоор 20 сая төгрөгийн газар доорх дулааны байгууламж хийгдсэн, хандиваар 1.4 сая төгрөгийн алаг зам авсан, 2.5 сая төгрөгийн хурд сааруулагч хөрөнгө оруулалтаар хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2022 онд нийт 250 хүүхэд сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 325 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамруулж биелэлт 130 хувьтай байна.

021020183

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. “

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,954,259.62	94,199,026.62
35	БАРАА МАТЕРИАЛ	86,954,259.62	94,199,026.62
351	Түүхий эд материал	624,000.00	00.00
35130	Эм боох материал	624,000.00	00.00
354	Хангамжийн материал	86,330,259.62	94,199,026.62
35410	Бичиг хэргийн материал	2,430,693.00	2,048,510.00
35420	Аж ахуйн материал	72,003,629.62	89,717,949.62
35440	Түлш, шатах тослох материал	4,216,000.00	600,000.00
35450	Барилгын засварын материал	330,000.00	00.00
35460	Хүнсний материал	7,349,937.00	1,832,567.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	982,692,244.82	1,001,768,173.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	982,692,244.82	1,001,768,173.27
392	Биет хөрөнгө	972,092,244.82	991,168,173.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	968,439,250.00	968,439,250.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,255,295.96	-54,395,950.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,620,978.00	53,175,978.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,784,406.48	-33,960,846.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,816,594.24	114,019,194.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	-79,663,474.94	-84,038,052.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,000,000.00	25,850,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.04	-1,625,000.04
39217	Ном	3,418,600.00	3,703,600.00
393	Биет бус хөрөнгө	10,600,000.00	10,600,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,600,000.00	10,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,069,646,504.44	1,095,967,199.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,972,458.00	8,665,357.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,972,458.00	8,665,357.20
413	Өглөг	5,972,458.00	8,665,357.20
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,972,458.00	3,651.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	5,517,809.00
4136	Бусад өглөг	00.00	3,143,897.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	3,143,897.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,063,674,046.44	1,087,301,842.69
51	Засгийн газрын хувь оролцоо	1,063,674,046.44	1,087,301,842.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	205,511,552.00	205,511,552.00

51101	Өмч: - төрийн	205,511,552.00	205,511,552.00
512	Хуримтлагдсан үр дүн	217,620,012.52	241,247,808.77
51210	Өмнөх үеийн үр дүн	217,620,012.52	217,620,012.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	23,627,796.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	640,542,481.92	640,542,481.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,069,646,504.44	1,095,967,199.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,001,097,625.00	1,053,782,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	202,593,700.00	68,235,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	202,593,700.00	68,235,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	202,593,700.00	68,235,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	202,593,700.00	68,235,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,474,125.00	985,546,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	895,485,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	895,485,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	742,029,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,035,411.00	2,270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,035,411.00	2,270,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,194,100.00	87,791,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,194,100.00	87,791,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,244,614.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,244,614.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	826,261,606.51	1,015,340,803.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	826,261,606.51	1,015,340,803.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	729,157,822.85	997,444,041.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	574,176,281.91	704,906,102.00
210101	Үндсэн цалин	574,176,281.91	704,906,102.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,339,087.43	81,273,676.20
210201	Тэтгэврийн даатгал	70,339,087.43	81,273,676.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,989,640.00	49,674,509.00
210301	Гэрэл, цахилгаан	4,116,740.00	6,917,291.00
210302	Түлш, халаалт	23,322,900.00	42,075,618.00
210303	Цэвэр, бохир ус	1,550,000.00	681,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,152,500.00	1,820,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,402,500.00	1,820,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.00	00.00
2105	Нормативт зардал	22,366,838.00	107,674,220.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,091,227.00	1,537,500.00
210502	Хоол, хүнс	21,275,611.00	106,136,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,122,250.00	6,608,180.00
210604	Урсгал засвар	1,122,250.00	6,608,180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,049,000.00	2,060,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	2,060,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,962,225.51	42,927,054.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,487,470.00	12,310,383.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,474,755.51	27,816,671.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,103,783.66	17,896,762.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,205,772.00	8,003,900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,244,614.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,961,158.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	70,898,011.66	9,892,862.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	70,898,011.66	9,892,862.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	174,836,018.49	38,441,196.25
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	14,813,400.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	14,813,400.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-14,813,400.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	174,836,018.49	23,627,796.25

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	642,443,781.92	40,882,694.03	888,838,027.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,901,300.00	1,901,300.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,511,552.00	642,443,781.92	42,783,994.03	890,739,327.95
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	35,030,178.89	35,030,178.89
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	640,542,481.92	217,620,012.52	1,063,674,046.44
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	640,542,481.92	217,620,012.52	1,063,674,046.44
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,511,552.00	640,542,481.92	217,620,012.52	1,063,674,046.44
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	23,627,796.25	23,627,796.25
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552.00	640,542,481.92	241,247,808.77	1,087,301,842.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	798,503,925.00	985,546,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	798,503,925.00	985,546,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	895,485,500.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	895,485,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	742,029,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,035,411.00	2,270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,035,411.00	2,270,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,194,100.00	87,791,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,194,100.00	87,791,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,244,614.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,244,614.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	798,503,925.00	985,546,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	798,503,925.00	985,546,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	701,400,141.34	967,649,738.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,203,824.03	708,967,824.00
210101	Үндсэн цалин	544,915,827.34	708,967,824.00
210102	Нэмэгдэл	22,371,370.69	00.00
210104	Урамшуулал	916,626.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,339,087.31	81,273,676.00
210201	Тэтгэврийн даатгал	64,740,187.31	81,273,676.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,399,700.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,119,700.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	280,000.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,799,500.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,506,140.00	37,412,500.00
210301	Гэрэл, цахилгаан	4,116,740.00	6,635,691.00
210302	Түлш, халаалт	22,839,400.00	30,095,209.00
210303	Цэвэр, бохир ус	1,550,000.00	681,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,183,900.00	1,820,300.00
210401	Бичиг хэрэг	627,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,402,500.00	1,820,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	49,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	226,100.00	00.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	128,500.00	00.00
2105	Нормативт зардал	24,731,427.00	103,372,438.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,182,627.00	272,000.00
210502	Хоол, хүнс	22,141,950.00	103,100,438.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,406,850.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	281,600.00	00.00
210604	Урсгал засвар	281,600.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,049,000.00	2,060,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	2,060,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,105,163.00	32,243,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	17,134,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,105,163.00	15,108,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,103,783.66	17,896,762.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,205,772.00	8,003,900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,244,614.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,961,158.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	8,003,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	70,898,011.66	9,892,862.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	70,898,011.66	9,892,862.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	983,276,500.00	975,653,638.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	983,276,500.00	975,653,638.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	975,272,600.00	967,649,738.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,875,700.00	708,967,824.00
210101	Үндсэн цалин	546,027,000.00	708,967,824.00
210102	Нэмэгдэл	136,711,900.00	00.00
210104	Урамшуулал	19,136,800.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,365,800.00	81,273,676.00
210201	Тэтгэврийн даатгал	60,088,900.00	81,273,676.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,984,800.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,740,100.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,421,700.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,130,300.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,312,500.00	37,412,500.00
210301	Гэрэл, цахилгаан	4,212,500.00	6,635,691.00
210302	Түлш, халаалт	35,700,000.00	30,095,209.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	681,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	1,820,300.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	1,820,300.00
2105	Нормативт зардал	109,548,500.00	103,372,438.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	272,000.00
210502	Хоол, хүнс	109,548,500.00	103,100,438.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,072,000.00	2,060,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,072,000.00	2,060,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33098100.00	32243000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,448,100.00	17,134,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,650,000.00	15,108,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8003900.00	8003900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,003,900.00	8,003,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,003,900.00	8,003,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	985,546,500.00	985,546,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	895,485,500.00	895,485,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	895,485,500.00	895,485,500.00

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	87,791,000.00	87,791,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	87,791,000.00	87,791,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	51.00	51.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00
620004	Гэрээт ажилтан	05.00	05.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган сумын 1 дүгээр цэцэрлэг нь хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хүүхдийн хөгжлийг төлөвшил сурлагын амжилт чанарыг сайжруулах, хүүхдийн сурах үйлийг дэмжих, багшийг мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх, сурлагын хоцрогдол арилгах, үнэлгээнд ахиц гаргаж ажиллахад бүх талын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготойгоор хүүхэд хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөн танхимын хэлбэрээр явуулж байна, Төв цэцэрлэгт нийт 175 хүүхдийн сургах хүчин чадалтай бөгөөд одоогийн байдлаар 250 хүүхэд, Баянсудал багийн цэцэрлэгт 75 хүүхэд сургах хүчин чадалтай бөгөөд 75 хүүхэд суралцаж байна. Тус цэцэрлэг нь удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 28, үйлчлэх ажилтан 17, гэрээт ажилтан 5 нийт 51 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн тохирсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилладаг байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26.3 сая төгрөгөөг буюу 2.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	86.9	94.2	7.2
Үндсэн хөрөнгө	982.7	1,001.8	19.1
Нийт хөрөнгө	1,069.6	1,096.0	26.3
Өр төлбөр	5.9	8.6	2.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,063.7	1,087.3	23.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,063.7	1,087.3	23.6

Дээрх хүснэгтээс харахад Булган сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны жилийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26.3 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь үндсэн хөрөнгө ба бараа материалын данстай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1- заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 983.3 сая төгрөгөөр баталж, нийт зарлагыг 983.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсрол Шинжлэх Ухааны яамнаас тус байгууллагын төсвийг 895.5 сая төгрөгөөр батлан ирүүлжээ. Дээд шатны байгууллагаас шагнал урамшуулалд 0.3 сая, Улаан загалмай нийгэмлэгээс 2.0 сая төгрөгийг төсөвлөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 983.3 сая төгрөгийн төсөв баталснаас 895.5 сая төгрөгийг улсын төсвөөс 87.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 983.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос тусгай зориулалт, улсын төсвөөс 895.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 87.8 төгрөг, үүн дээр дээд шатны байгууллагаас 0.2 сая төгрөг, Улаан загалмай нийгэмлэгээс 2.0 сая төгрөгийн орлого нэмэгдэж нийт 985.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 975.6 сая төгрөгийг зарцуулж 9.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 985.5 сая төгрөг буюу 90 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа хангамж, бараа материалын зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, үндсэн үйл ажиллагааны зардлыг төлөвлөгөөний дагуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
81605	Эрүүл мэндийг дэмжих	2.8	2.8	-	100%
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	109.5	99.8	9.9	91%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4.2	4.2	-	100%
81823	Боловсролын байгууллагын багш,	2.8	2.8	-	100%
81834	Боловсролын стандарт, сургалт	652.2	652.1	0.012	99%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	123.9	123.9	-	100%
83602	ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	0.27	0.27	-	100%
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	40.3	40.3	-	100%
80112	Нийтлэг үйлчилгээ	47.5	47.5	-	100%
Нийт дүн		983.5	973.7	9.9	890%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “*Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна*” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагад нэмэлт санхүүжилт олгогдоогүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “*Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана*” гэж заасны дагуу Булган сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын гүйцэтгэл, хөрөнгө, бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг Эл Би Альфа Экспэйншин Аудит ХХК-ны аудитор Г. Баясгалан 2023 оны 01 дүгээр сарын 27-наас 2023 оны 02 дугаар сарын 02-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А. Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х. Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,053.7 төгрөгөөс 0.5 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй бөгөөд тодотгосон төсвөөс 7.6 сая төгрөгийн хэмнэлтийг хийж улсын төсөвт эргүүлэн төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 156 мэдээллээс хугацаандаа оруулсан 136, хугацаа хоцроосон мэдээлэл 6, огт мэдээлээгүй 14, шилэн дансны цахим системд тендэрт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, төсвийн шууд захирагчийн төсөв өмч хөрөнгө мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн шийдвэрийг огт мэдээлээгүй байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	8.05	1	8.05	100%
Нийт дүн	1	8.05	1	8.05	100%

/сая төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар:

- Амралтын цалингийн тооцооллыг зөв оруулж тооцох
- Нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв мэдээлж тайланд тусгасан эсэх үйл ажиллагаанд анхаарч шалгах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн алдаа илэрснээс, 0.3 сая төгрөгийн алдааг залруулав.

5.1 Залруулсан алдаа

Тэтгэвэрт гарсан ажилтны 4 сард ногдох амралтын цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн тооцоололд оруулаагүй орхигдуулсныг залруулж нөхөн тайлагнасан.

Аудитын явцад нийт 0.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, 0.3 сая төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоов.

5.2 Төлбөрийн акт

5.2.1 Ажилчдын ээлжийн амралтын цалин

Илрүүлэлт: Багш ажилтнуудын ээлжийн амралтын цалинг бодсон дүн, олгосон цалингийн дүнгээс 0.3 сая төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1- д “Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэтгэвэрт гарсан ажилтны цалингаас суутгасан нийгмийн даатгалыг нийгмийн даатгалын тайланд тусгаагүй	1	0.3	1	0.3			1	0.3				
Дүн	1	0.3	1	0.3			1	0.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Багш ажилтнуудын ээлжийн амралтын цалинг бодсон дүн, олгосон цалингийн дүнгээс илүү олгосон	1	0.3	1	0.3				
Дүн	1	0.3	1	0.3			1	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х. БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А. ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

ЭЛ БИ АЛЬФА ЭКСПЭЙНШИН АУДИТ ХХК- НИЙ

АУДИТОР:




Г. БАЯСГАЛАН